



I-V/2022


Тархаасан: 2022 оны 6 дугаар сарын 13



Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 7481 (79.8%)-ээр өссөн байна

Бүртгэгдсэн гэмт хэрэг 2022 оны эхний 5 сард 16850 болж, өмнөх оны мөн үеэс 7481 (79.8%)-ээр өсжээ. Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс өсөхөд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 5846 (2.2 дахин), хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 1297 (45.3%), хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 239 (96.8%), хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 125 (57.1%)-аар өссөн нь голлон нөлөөлжээ.

ЗУРАГ 1. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, сараар



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 870 хэргийн 63 (7.2%) нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг)-ээр зүйлчлэгдсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 2022 оны эхний 5 сард 63 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2 (3.3%)-оор өсжээ. Харин 2022 оны 5 дугаар сард 12 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх сараас 2 (14.3%)-оор буурсан байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2022 оны эхний 5 сард 4882 зөрчил бүртгэгдсэний 3764 (77.1%) зөрчлийг шалган шийдвэрлэжээ. Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн нийт зөрчил өмнөх оны мөн үеэс 767 (18.6%)-гоор, шийдвэрлэсэн гэр бүлийн хүчирхийллийн нийт зөрчил 789 (26.5%)-өөр тус тус өсжээ.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг 2022 оны эхний 5 сард 78 болж, өмнөх оны мөн үеэс 34 (77.3%)-өөр өссөн байна. Харин 2022 оны 5 дугаар сард 16 болж, өмнөх сарын түвшинд байна.


Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2022 оны эхний 5 сард 870 болж, өмнөх оны мөн үеэс 274 (46.0%)-өөр, эмэгтэй хүн оролцсон хэрэг 2545 болж, 1223 (92.5%)-аар, хүүхэд оролцсон хэрэг 600 болж, 383 (2.8 дахин)-аар, согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 2588 болж, 846 (48.6%)-гаар, бүлэглэн үйлдсэн хэрэг 732 болж, 222 (43.5%)-оор, мансуурсан үедээ үйлдсэн хэрэг 81 болж, 13 (19.1%)-аар тус тус өсжээ.

ЗУРАГ 2. УЧИРСАН ХОХИРОЛ БОЛОН НӨХӨН ТӨЛҮҮЛСЭН ХОХИРОЛ, сараар, тэрбум төгрөгөөр



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2022 оны эхний 5 сард 173.7 тэрбум төгрөг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 82.6 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирол 99.8 (2.3 дахин) тэрбум төгрөгөөр, нөхөн төлүүлсэн хохирол 61.1 (3.8 дахин) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 3. ГЭМТ ХЭРЭГТ ХОЛБОГДСОН ЯЛЛАГДАГЧ, насны бүлгээр, жил бүрийн эхний 5 сарын байдлаар



Гэмт хэрэгт холбогдсон нийт яллагдагчдын тоо 2022 оны эхний 5 сард 10323 болж, өмнөх оны мөн үеэс 4280 (70.8%)-аар өсжээ. Нийт гэмт хэрэгт холбогдсон яллагдагчийн 674 (6.5%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 2163 (21.0%) нь эмэгтэйчүүд байна.

ХҮСНЭГТ 1. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ХОХИРСОН, ГЭМТСЭН, НАС БАРСАН ХҮН, насны бүлгээр, хүйсээр, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

Үзүүлэлт	Хохирсон хүн		Гэмтсэн хүн		Нас барсан хүн	
	2021	2022	2021	2022	2021	2022
	I-V	I-V	I-V	I-V	I-V	I-V
7 хүртэлх	56	62	23	31	18	16
8-17	335	879	114	285	8	20
18-29	2 363	4 280	862	1 312	39	53
30-39	2 959	5 359	1 010	1 492	62	88
40-49	1 901	3 422	585	835	62	78
50-59	916	1 774	300	390	45	63
60-69	308	604	73	129	15	25
70, түүнээс дээш	91	129	31	37	8	10
Улсын дүн	8 929	16 509	2 998	4 511	257	353
Эмэгтэй	4 066	7 493	1 152	1 685	65	94

Гэмт хэргийн улмаас хохирсон хүн 2022 оны эхний 5 сард 16.5 мянга болж, 941 (5.7%) нь 18 хүртэлх насны хүүхэд, 7493 (45.4%) нь эмэгтэйчүүд байна.


Гэмт хэргийн улмаас 2022 оны эхний 5 сард 4511 хүн гэмтэж, 353 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс гэмтсэн хүн 1513 (50.5%)-аар, нас барсан хүн 96 (37.4%)-гаар өсжээ.

Улсын хэмжээнд 2022 оны эхний 5 сард 32.0 мянган хүн эрүүлжүүлэгдэж, 7.0 мянган хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеэс эрүүлжүүлэгдсэн хүн 3455 (12.1%)-аар, баривчлагдсан хүн 1289 (22.4%)-өөр тус тус өссөн байна.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэст 2022 оны эхний 5 сард 210 авлигын хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 56 (36.4%)-гаар өсжээ. Авлигын гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс өсөхөд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэг 52 (44.4%)-оор өссөн нь голлон нөлөөлжээ.

Бүртгэгдсэн 210 авлигын хавтаст хэргийг Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар бүлгийн зүйлээр ангилахад 169 (76.8%) нь эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, 30 (13.6%) нь хахууль авах гэмт хэрэг, 11 (5.0%) нь хахууль өгөх гэмт хэрэг, 5 (2.3%) нь үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг, 3 (1.4%) нь төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг, 2 (0.9%) нь хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах гэмт хэрэг байна.

ЗУРАГ 4. АВЛИГЫН ГЭМТ ХЭРЭГ, хэргийн төрлөөр, жил бүрийн эхний 5 сарын байдлаар



Ойлголт, тодорхойлолт

Гэмт хэрэг: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг ойлгоно.

16, түүнээс дээш насны 10000 хүнд ногдох бүртгэгдсэн гэмт хэрэг: Тухайн хугацаанд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн тоог 16, түүнээс дээш насны хүн амын жилийн дундаж тоонд харьцуулж, 10000-аар үржүүлж тооцно.

Хохирогч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

Гэмт хэргийн хохирол: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.

Яллагдагч: Монгол Улсын “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай” хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцсан сэжигтнийг ойлгоно.



Эх үүсвэр:

Цагдаагийн ерөнхий газрын мэдээлэл

Ангилал, код:

Гэмт хэргийн статистикийн олон улсын ангилал

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 07 дугаар сарын 19

Нийгмийн статистикийн газрын дарга
Э.Эрдэнэсан
Утас: (976-51)-266414

Нийгмийн статистикийн газрын
статистикч Ц.Дулмаа
Утас: (976-51)-263966



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212